

“ЗАВХАНБАЯЛАГ” ХК-НИЙ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024-03-20

Дугаар 02

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, 60.2, 60.4 дэх хэсэг, 62 дугаар зүйлийн 62.1.7, 62.1.9, 62.1.13, 62.1.15 дахь заалт, 76 дугаар зүйлийн 76.1.2, 76.1.3 дахь заалт, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолыг тус тус үндэслэн “Завхан баялаг ” хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. Компаний Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2024 оны 04-р сарын 30-ны 14 цагт Улиастай хотын өөрийн Компаний байранд танхимаар болон цахим хэлбэрээр хуралдуулахаар тогтоосугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцүүлсүгэй.
 - 2.1. Компаний гүйцэтгэх удирлагаас 2023 онд хийсэн ажлын тайлан, 2024 онд хийх ажлын тухай.
 - 2.2. Компаний 2023 оны санхүүгийн тайлан түүнд хийсэн хараат бус Аудитын дүгнэлтийг батлах
 - 2.3. ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагын төсвийг батлах.
 - 2.4. Ноогдол ашиг хувиарлах эсэх талаар гарсанТУЗ-ын шийдвэрийг батлах.
 - 2.5. ТУЗ-ын гишүүдийг шинээр сонгох.
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2022 оны 4-р сарын 10-ны өдөр байхаар тогтсугай.
4. 2023 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдэд хурлын зарыг 2024 оны 3-рсарын 25-ны өдрөөс хойш хоёроос доошгүй өдөр дутмын сонин, Компанийн болон Монголын хөрөнгийн бирж ХК-ийн цахим хуудас, бусад мэдээллийн хэрэгслээр мэдээлж зарыг 2024 оны 4-р сарын 09-ны өдөр анх нийтэд мэдээлсэн хэлбэрээр хэвлэл мэдээллийн хэрэгслээр давтан мэдээллэхийг хурал зохион байгуулах комисст даалгасугай.
5. 2023 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийг 1 дүгээр хавсралтаар, танилцах баримт бичгийн жагсаалтыг 2 дугаар хавсралтаар, хурлын санал авах хуудсийг 3 дугаар хавсралтаар тус тус баталж, компанийн хувьцаа эзэмшигчдэд 2024 оны 3 дугаар сарын 30 -ний өдрөөс эхлэн ажлын өдрүүдэд 10:00-17:00 цагийн хооронд “Завхан баялаг ” хувьцаат компанийн төв байранд болон цахим хэлбэр танилцах боломжийг бүрдүүлж ажиллахыг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /Б.Түмэндэмбэрэл/-д даалгасугай.
6. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдээс санал авах “Саналын хуудас”-ын агуулгыг 3 дугаар хавсралтаар баталсугай.

7. Хувьцаа эзэмшигчдээс “Саналын хуудас”-ыг харьяалагдах үнэт цаасны компаниар нь дамжуулан хүлээн авах сүүлийн өдрийг 2024 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 17:00 цаг байхаар тогтсугай.
8. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг удирдах хурлын даргаар Ю.Бат-Эрдэнийг томилсугай.
9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын даргаар Б.Мөнхбат, гишүүдээр Д.Гантөмөр, Д.Даваажаргал нарыг тус тус томилсугай.
10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зохион байгуулах комиссын даргаар С.Нямсүрэн, гишүүдээр Б.Түмэндэмбэрэл, Я.Ганбаатар нарыг тус тус томилсугай.
11. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зохион байгуулах бэлтгэлийг хангаж ажиллахыг хурал зохион байгуулах комисс (С.Нямсүрэн)-д үүрэг болгосугай.
12. Хуралд оруулах асуудлыг боловсруулж, Хурлын зар материалыг брокерийн компани ба Монголын хөрөнгийн биржид өгч, хувьцаа эзэмшигчидэд холбогдох мэдээлэлийг хүргэн, Хурлын бэлтгэл ажлыг тогтоосон хугацаанд нь гүйцэтгэж ажиллахыг Гүйцэтгэх захирал Ю.Бат-Эрдэнэ, хурал зохион байгуулах комисс (С.Нямсүрэн) нарт даалгасугай

ТУЗ-ын дарга



Ю.Зочин-Эрдэнэ